



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,  
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 29 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн өмчөөс шилжүүлсэн, нийт 60,000,000.00 (жаран сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт эзэмшүүлсүгэй.

2. Говь-Алтай аймгийн өмчөөс шилжүүлсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хавсралтад заасан хөрөнгө (тээврийн хэрэгсэл)-ийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Автомашин урсны дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

0004

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны дугаар сарын 17-ний өдрийн  
дугаар тогтоолын хаворалт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашин нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Тоёота лексус 470, 00-03 ГАУ (арал-tjhm00w333532129)	2011	1	60,000,000.00	5,000,000.00	2
	Нийт дүн			60,00,000.00 (жаран сая)	5,000,000.00 (таван сая)	